



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 4, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-ийн нэгжийн зохицуулагч Б.Батцэндэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
 2018 оны 10 дүгээр сарын 20-ны өдрийн  
 486 дугаар тогтоолын хавсралт



**"ЗАМЫН-ҮҮДИЙН ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ"-ИЙН НЭГЖИЙН  
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР  
 ХУДАЛДАХ АВТОМАШИН**

| Д/д | Суудлын автомашины марк,<br>улсын дугаар, арлын дугаар                     | Үйлдвэр-<br>лэсэн/<br>Ашиглалтад<br>орсон он | Балансын үнэ<br>(төгрөг)                          | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                 | Үлдэгдэл өртөг<br>(төгрөг) | Худалдах доод<br>үнэ (төгрөг)     |
|-----|--|--|---|---|----------------------------|-----------------------------------|
| 1   | Суудлын автомашин Тоёото<br>"Лексус-470", УБА 97-77,<br>JT8HT00W8W 0001525 | 1998/2005                                    | 20,000,000.00                                     | 20,000,000.00                                     | -                          | 2,000,000.00                      |
|     | <b>Нийт дүн</b>  |  | <b>20,000,000.00</b><br>(хорин сая<br>таван зуун) | <b>20,000,000.00</b><br>(хорин сая таван<br>зуун) | -                          | <b>2,000,000.00</b><br>(хоёр сая) |